



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020.04.13-2020.04.20

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-аас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!

ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Хувьцааны индексүүд

Америк (17:10 04/03/20)

Нэр	Үнэ цэнэ	Өөрчлөлт	Индексийн өгөөж			
			1-өдөр	5-өдөр	1-сар	1-жил
DJIA	24,242.49	704.81	2.99%	2.17%	26.43%	-8.72%
S&P 500	2,874.56	75.01	2.68%	3.02%	24.71%	-1.05%
Nasdaq 100	8,832.41	74.58	0.85%	7.21%	26.28%	13.89%
Russell 2000	1,229.10	51.01	4.33%	-1.41%	21.23%	-21.50%
NYSE Comp.	11,208.29	390.27	3.61%	0.63%	22.72%	-13.27%

Европ

FTSE 100	5,747.63	-39.58	-0.01%	-0.67%	11.49%	-23.07%
DAX	10,301.54	-57.57	-0.54%	0.29%	18.36%	-13.54%
CAC 40	4,460.66	38.35	-0.85%	-1.01%	10.19%	-20.03%
Euro Stoxx 50	2,867.42	-20.88	-0.72%	-0.88%	15.34%	-18.07%
FTSE MIB	16,933.38	-129.29	-0.76%	-3.95%	8.78%	-22.90%

Ази, Номхон далай

Nikkei 225	19,669.12	-228.14	-1.15%	3.29%	16.47%	-11.47%
Hang Seng	24,330.02	49.98	-0.21%	0.12%	12.14%	-18.80%
Shanghai	2,852.55	14.06	0.50%	2.50%	7.23%	-11.27%
BSE Sensex	31,648.00	59.28	0.19%	3.12%	21.81%	-18.11%
S&P/ASX 200	5,353.00	-134.5	-2.45%	-0.64%	17.75%	-14.49%

Валют

EUR/USD	1.0865	0.001	0.09%	-0.39%	1.31%	-3.46%
USD/JPY	107.73	0.2	0.18%	-0.03%	-3.16%	-3.76%
GBP/USD	1.2466	-0.0034	-0.27%	-0.31%	7.97%	-3.98%
USD/CHF	0.9683	0.0016	0.17%	0.11%	-1.68%	-4.68%
AUD/USD	0.637	0.0007	0.11%	-0.20%	9.32%	-10.72%
USD/CNY	7.0731	-0.0001	0.00%	0.29%	-0.27%	5.42%
USD/HKD	7.7504	-0.0001	0.00%	-0.02%	-0.07%	-1.20%
USD/CAD	1.4094	0.001	0.07%	1.56%	5.85%	6.37%
USD/MXN	25.0125	0.0093	0.66%	1.36%	-2.83%	5.58%
Bitcoin (BTC/USD)	7077	15.1	0.21%	3.66%	10.44%	31.52%
U.S. Dollar Index	100.015	0.179	0.18%	0.53%	-3.08%	3.16%

Түүхий эд (ам. доллараар)

Түүхий нефтийн фьючерс	22.74	-2.29	-9.15%	1.43%	-4.29%	-65.33%
Brent нефтийн фьючерс	27	-1.08	-3.85%	-15.32%	-1.89%	-63.64%
Алтны фьючерс	1696	-2.8	-0.18%	-3.83%	8.64%	32.81%
Мөнгөний фьючерс	15.37	0.075	0.49%	-1.88%	15.56%	2.67%
Зэсийн фьючерс	2.3305	-0.014	-0.60%	0.41%	11.64%	-19.73%
Байгалийн хийн фьючерс	1.751	-0.002	-0.11%	1.39%	10.40%	-30.83%

Засгийн газрын бонд (10-жилийн)

Купон %	Улс	Өгөөж (%)	Өгөөжийн өөрчлөлт	Өгөөжийн зөрүү (Америк)
1.50	Америк	0.63	-0.014	-
0.00	Герман	-0.472	-0.002	-110.6
4.75	Их Британи	0.314	0.011	-31.7
2.50	Австрали	0.839	-0.015	20.6
3.00	Шинэ Зеланд	0.926	-0.034	29.3
0.00	Франц	0.055	0.034	-57.9
1.35	Итали	1.932	0.149	129.9
0.50	Испани	0.892	0.09	25.8

2020 оны 4-р сарын 13- 4-р сарын 20 хооронд



Онцлох үйл явдлууд

- Энэ долоо хоногт Coca-Cola Co, Netflix Inc, Delta Air Lines Inc зэрэг компаниудын орлогын тайлан гарах бөгөөд тэдгээр нь коронавирусийн цар тахал, түүний эсрэг авч буй арга хэмжээнүүд АНУ-ын бизнесийн орчин эдийн засагт хэрхэн өөрчилж байгааг илтгэх нэгэн индикатор болно.
- COVID-19 цар тахлын технологийн компаниудын санхүүгийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөлөл өөр өөр байна. Интернет худалдааны дэлгүүрээс эхлээд виртуал уулзалт, мэдээллийг хуваалцах хамтран эзэмших платформууд, Amazon.com Inc, Microsoft Corp., Intel Corp гэх мэт компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогод үүсээд буй нөхцөл байдал хөл хорио эерэгээр нөлөөлж байна. Энэ нь уг компаниудыг эдийн засаг хэвийн байдалдаа шилжиж эхлэхэд зах зээл дээр илүү сайн байр суурь эзлэх боломжийг олгоно. Нөгөөтээгүүр, Facebook Inc болон Google-ийн эцэг Alphabet Inc зэрэг компаниудын зар сурталчилгааны орлого огцом унаж, Apple Inc нь түүхэндээ цөөн удаа гаргаж байсан ашгийн тухай анхааруулга өглөө.
- Даваа гаригт Европт зах зээл нээгдсэнээр West Texas Intermediate буюу АНУ-ын газрын тосны жишиг үнэ 17.9 хувиар унаж баррель нь 14,99 америк долларт хүрсэн нь 1999 оноос хойших хамгийн доод үзүүлэлт боллоо. АНУ-ын газрын тосны үнэ хорь гаруй жилийн хугацаан дахь хамгийн доод түвшинд хүрч буурсан нь коронавирусын тахлын тархалтаас үүдэн дэлхий дахинд газрын тосны эрэлт буурч, нөгөө талаас хангалттай хадгалах орчин байхгүй нөхцөл байдалд хүрсэнтэй холбож үзэж байна. Шинжээчид энэхүү сүүлийн уналтыг хамгийн их арилжаалагдсан газрын тосны фьючерсийн гэрээ дуусахаас өмнө тохиолдсон учир газрын тос олборлогчдод нийлүүлэлтээ дахин багасгах дарамтыг бий болгоно гэж үзжээ.

ГАДААД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 13- 4-р сарын 20 хооронд

Global overview as of 7:11 AM ET 04/20/2020



ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


2020 оны 4-р сарын 13- 4-р сарын 20 хооронд

Johns Hopkins-н мэдээлснээр Даваа гарагийн байдлаар COVID-19 халдварын тоо дэлхий дахинд 2.4 саяд хүрч 165,000 дээш тооны хүн тус өвчнөөр нас бараад байна.


Америк

- АНУ-н мужуудын засаг дарга нар тахлын эсрэг яаралтай тэмцэлд гол анхаарлаа төвлөрүүлж байгаа ч, мужуудын төсвийн алдагдал арван жилийн өмнөх санхүүгийн хямралын үеийнхээс ч илүү гарах эрсдэл ойрхон байгааг сануулж байна. Өнгөрсөн 3-р сард сүүлийн санхүүгийн хямралаас хойших хамгийн олон тоогоор ажлын байр алдагдсан байна.
- Тэргүүлэх төсөв болон бодлогын төвөөс Мягмар гарагт гаргасан судалгаагаар улсын орлогын алдагдлын дүн зургадугаар сар гэхэд 105 тэрбум америк доллар, дараагийн санхүүгийн жилд 290 тэрбум америк долларт хүрэх боломжтой гэсэн нь сүүлийн хямралын хамгийн хүнд он болох 2010 оныхоос ч давсан таамаглал боллоо.
- Мужуудын дэд бүтцийн зардлыг ДНБ-д эзлэх хувиар авч үзвэл 50 жилийн хамгийн доод түвшинд хүрээд байна.
- Холбооны Нөөцийн Банк өндөр эрсдэлтэй бондыг дэмжихээ амлаж, зах зээлийг цочирдуулсны дараагаар хөрөнгө оруулагчид уг бондуудад 10.5 тэрбум америк долларын мөнгөн урсгалыг оруулсан байна. Өнгөрсөн долоо хоногт ХНБ өнгөрсөн сард зарласан корпорацын бонд болон зээлийн ETF худалдан авах хөтөлбөрт өндөр эрсдэл өндөр өгөөж бүхий ETF-үүдийг нэмж оруулжээ. Энэхүү үйлдэл нь зах зээлд хөрвөх чадварыг нэмэгдүүлж, коронавирусын улмаас уналтад ороод буй АНУ-ын бизнесүүдийн зээлийн өртгийг хөнгөвчлөх, зээлийн сувгийг олшруулах зорилготой байв.

Ажилгүйдлийн даатгалын нэхэмжлэл, долоо хоногийн дунджаар



Аж үйлдвэрлэлийн сарын өөрчлөлт



- Өнгөрсөн долоо хоногт 5.2 сая гаруй америкчууд шинээр ажилгүйдлийн даатгалын нэхэмжлэл хүссэнээр нэг сарын хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж хүссэн иргэдийн тоог 22 саяас буюу Америкийн нийт ажиллах хүчний 8.2 хувиас давууллаа. АНУ-д шинэ байшин барилгын үйл ажиллагаа 22.3 хувиар буурсан байна. Үүний зэрэгцээ АНУ-ын дунд Атлантын бүсийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааны хэмжүүр болох Philadelphia Fed-ийн үйлдвэрлэлийн индекс нь -56.6 хүртэл буурсан нь 1980 оны 7-р сараас хойших хамгийн тааруу үзүүлэлт боллоо.
- Дональд Трамп АНУ-ын шинэ коронавирусын тохиолдол дээд цэгтээ хүрсэн учир аажмаар эдийн засгаа сэргээх нь зүйтэй гэж үзсэнээр дараагийн Пүрэв гарагт эдийн засгийг сэргээх удирдамжийг зарлах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч Лхагва гарагт 24 цагийн хугацаанд 2,992 хүн амиа алдсан тохиолдол бүртгэгдсэн бөгөөд дараалан хоёр өдрийн турш уг өвчнөөр нас барагсдын тоо 2000-г давсан байна. АНУ-д коронавирусээр амиа алдагсдын тоо одоо 28,000-г, харин батлагдсан тохиолдлын тоо 632,000-г давжээ.
- АНУ-ын аж үйлдвэрийн үйлдвэрлэл дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойших сарын хамгийн огцом бууралтыг үзүүлсэн бол жижиглэнгийн худалдаа 1992 оноос буюу өгөгдөл цуглуулж эхэлснээс хойших хамгийн их хэмжээгээр буурсан байна.
- Дэлгүүр, рестораны борлуулалтын голлох хэмжүүр болох жижиглэнгийн худалдаа 8.7 хувиар буурч дөрвөн жилийн өсөлтөө арилгасны АНУ-н Худалдааны Тэнхимээс мэдээллээ.
- Жижиглэнгийн борлуулалтын мэдээлэл иргэдийн хэрэглээ, зарлага болон амьдралын хэв маяг COVID-19-н эсрэг авч буй арга хэмжээний улмаас хэрхэн өөрчлөгдөж буйг тод харуулжээ. Уг тайланд хэрэглэгчдийн хүнсний дэлгүүрүүдээр хийсэн худалдан авалт 27 хувиар өссөн боловч баар, ресторануудад 27 хувиар, шатахуун түгээх станцуудын дэлгүүрүүдэд 17 хувиар тус тус буурсан байна.

ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


2020 оны 4-р сарын 13- 4-р сарын 20 хооронд

Евро бүс

Европын орнуудад коронавирусын улмаас эдийн засгийн хаагдсан тул 59 сая хүртэлх ажлын байр алдагдах эрсдэлтэй байна. McKinsey-ийн шинжээчид ЕХ болон Их Британид хувийн хэвшилд ажил эрхлэгчдийн дөрөвний нэгээс илүү хувийнх нь ажлын байранд, ажлаа алдах, цагийн тоо эсвэл хөлс багасах зэргээр өөрчлөлт орж болзошгүй гэж дүгнэжээ.


- McKinsey-н гутрангуй үзэл буюу вирусийн тархалтыг хязгаарлах хатуу хөл хорио нийгмийн хязгаарлалтууд нь зуны турш үргэлжилсэн тохиолдолд ЕХ-ны ажилгүйдэл ирэх жил гэхэд одоо үеийнхээсээ 2 дахин ихсэн 11.2 хувь болж, 2024 он хүртэл хямралын өмнөх түвшинд эргэж орохгүй байх магадлалтай гэжээ. Үйлдвэрлэлийн салбарын хувьд үйлчилгээний салбар шиг муу биш ч гэсэн буурсан үзүүлэлттэй байна. Ирээдүйд итгэх итгэлийн судалгаа ч эхэлсэн 2012 оны долдугаар сард эхэлснээс хойших хамгийн доод цэгтээ хүрээ
- ОУВС энэ онд евро бүсийн эдийн засгийн өсөлт 7.5 хувиар унаж, ажилгүйдэл одоогийн 7.6 хувиасаа 10.4 хувь хүртэл өснө гэж таамаглаж байна. Зарим эдийн засагчид блокийн өмнөд хэсгийн орнуудын эдийн засгийн бууралт хоёр оронтой тоонд ч хүрч магадгүй хэмээн сануулжээ.
- Испани, Португал, Грек зэрэг улсууд коронавирусын халдвар эхлэх үед өмнөх хямралаасаа бүрэн гүйцэд сэргэж амжаагүй байсан байна. Итали улстай хамт эдгээр орнууд нь аялал жуулчлалын салбаараас эдийн засаг нь ихээхэн хамаардаг, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тоо харьцангуй олон зэрэг шалтгаанаар цар тахлын хямралд хамгийн эмзэг эдийн засагтай орнуудаар тодроод буй.
- Герман, Франц, Испаний төрийн албан тушаалтнууд хямралын эхний долоо хоногт л гэхэд 10 сая гаруй хүний цалинтай амралт хүссэн өргөдлийг хүлээн авсан байна.

50-с цөөн ажилтай компаниуд (нийт ажлын байрны тоонд эзлэх хувь)



Source: Moody's
© FT

Аялал жуулчлалын салбарт ажиллагсдын нийт ажлын байрны тоонд эзлэх хувь



Source: Moody's
© FT

Хятад

Хятадын эдийн засаг 3-р сарын сүүлээр 90% потенциалар ажиллаж байсан бол 4-р сарын 3-ны байдлаар 90-95 хувийн потенциалар ажиллаж байна. Хятадын томоохон аж ахуйн нэгж бараг цөм буюу 98.6 хувь нь харин жижиг аж ахуйн нэгжүүдийн дөрөвний гурваас дээш хувь буцаж хэвийн үйл ажиллагаандаа шилжсэнээр нийт ажилчдын 90 хувь нь ажилдаа эргэн ороод байна. Харин үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн сэргэлт харьцангуй удаашралтай байгаа бөгөөд томоохон хотууд дахь үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 1-р сарынхаа түвшний дөнгөж 36 хувьд нь хүрсэн байна.

Хятадын төсвийн бодлого: Блүүмбэргийн шинжээчдийн мэдээлснээр Хятадын төсвийн алдагдал 2019 онд байсан дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьтай тэнцэх түвшнээсээ өсөж 2020 онд түүхэн дэх хамгийн дээд цэг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 6.4 хувьд хүрэх төлөвтэй байна. Харин Хятадын засгийн газраас нэмэлт төсвийн дэмжлэг үзүүлсэн тохиолдолд 2020 оны төсвийн алдагдал ДНБ-ий 9.5 хувьд хүрч магадгүй юм. Ковид-19 цар тахалтай тэмцэх мөн эдийн засгаа дэмжих зориулалттай татварын хөнгөлөлтүүд болон нийгмийн халамжууд нь төсвийн зарлагыг ДНБ-ий 0.25 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэгдүүлж, төсвийн орлого 900 тэрбум юань буюу ДНБ-ий 0.8 хувьтай тэнцэх хэмжээгээр тасалдаж магадгүйд хүргээд байна. Одоогоор мэдэгдэж байгаа мэдээллүүдээс харахад төсвийн нийт дэмжлэг энэ онд 3 их наяд юань хүрэх боломжтой байна. Хятадын экспорт 2 болон 3-р сард огцом буурч, эдийн засаг нь 90-95 хувийн потенциалар ажиллаж байгаа ч бизнесийн идэвхжил дотоод гадаадын эрэлт аль аль нь төдийлөн сайн нэмэгдээгүй байна.

Хятадын мөнгөний бодлого: Хятадын Ардын Банк 4-р сарын 3-ны өдөр жижиг банкнуудын заавал байлгах нөөцийг 1 нэгж хувиар буулгасан нь цаашид үечлэн буулгаж 400 тэрбум юанийг чөлөөлнө гэсэн хүлээлтийг бий болгоод байна. Түүнчлэн хүүний коридорын доод утгыг 2008 оны хямралаас хойших хямралаас хойш анх удаагаа буулгаж 0.72 хувиас 0.35 хувь болгожээ.

COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ДЭЛХИЙН ТОМООХОН КОМПАНИУДЫН АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

2020 оны 4-р сарын 20

Гадаадын ихэнх томоохон компаниуд болон олон улсын байгууллагууд нь тодорхой газарзүйн бүс нутгийн эдийн засгийн цохилт, коронавирусийн тархалт зэргээс хамааран тохирох хариу арга хэмжээ авах хямралын менежментийн баг, ажлын хэсэг, хороог байгуулсан байна.

Мөн тэдгээрийн ихэнх нь ажилчдынхаа хувийн болон бизнесийн аяллыг хязгаарлахыг зөвлөж байгаа бөгөөд технологийн дэвшлийг, онлайн уулзалтын платформуудыг, аудио конференц уулзалт зэргийг ашиглан гэрээсээ ажиллах мэдээллийг түргэн шуурхай хүргэх тал дээр чухал ач холбогдол өгч эхэллээ.

Томоохон корпорациудийн COVID-19-н үед авч байгаа нийтлэг арга хэмжээ, үйлдлүүдэд:

1. Сургууль, цэцэрлэг хаагдсан, болон цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор асран халамжлагчийн үүрэг гүйцэтгэдэг ажилчиддаа тодорхой хугацаагаар цалинтай чөлөө олгох.
2. Зарим шаардлагад нийцсэн ажилчдынхаа орлогын хэлбэлзлийг зогсооход туслах зорилгоор ажилчдад урамшуулал, буцалтгүй тусламж эсвэл бусад санхүүгийн тусламж санал болгох.
3. Жижиглэнгийн худалдаа эсвэл салбар дэлгүүрүүдийнхээ зарим хэсгийг сайн дураараа хаах, болон үйлчилгээгээ түр эсвэл бүр мөсөн зогсоох
4. Тусламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагад болон байгууллагуудад туслах зорилгоор хөрөнгө босгох.
5. Компанийн үйл ажиллагааны зардлыг дэмжих, ажлын цаг нь багасаж орлого нь буурсан ажилтнуудынхаа орлогыг нөхөх ажилчдын цалин хөлсийг үргэлжлүүлэн төлж, ажлын байрыг хасахгүй байх зорилгоор зарим удирдлагын багийнхаа цалин хөлс болон бонусыг хасах.
6. Орлого буурсантай холбоотойгоор үйл ажиллагааны зардлаа ханахдаа ажилчдын ажлын байрыг хасахаас илүүтэй цалин хөлсгүйгээр ажлаа түр зогсоохыг хүсэх.
7. Алдагдсан орлогын хэмжээ хэт өндөр болсон тохиолдолд ажлын байрны тоог багасгах.
8. COVID-19-тэй холбоотой бүтээгдэхүүн худалдан авалтын ажлыг чухалчлах, үйлдвэрлэлээ уг чиглэлд голчлон шилжүүлэх
9. COVID-19-ээр халдварласан болон албан хорио цээрийн дор ажиллагсдад өвчний чөлөө олгох бодлогыг өргөжүүлэх
10. Боломжтой албан хаагчдыг алслагдсан газраас эсвэл гэрээс ажиллахыг хүсэх.

Эдгээр түгээмэл хариу арга хэмжээг дүгнэвэл бизнес гэхээс илүү ажилтан төвтэй, ажилчдын эрүүл мэнд, сайн сайхныг чухалд тооцсон байна. Хөрөнгө оруулалт бүхий л төрөлд багасах хандлагатай байгаа боловч алсын зайнаас ажиллах, виртуал хамтын ажиллагааны чадварыг дэмжих технологи, дэд бүтцэд хөрөнгө оруулалт голчлон хийгдэж байна. Эрсдэлийн менежментэд компаниуд бүс нутгийн хомстол, геополитикийн үйл явдлын улмаас төсөл удаашрах, зогсох, нэмэгдэл өртөг гарах зэргээс зайлсхийхээр газарзүйн дагуу ханган нийлүүлэгч бааз, үйлчлүүлэгчид болон гуравдагч талын үйлчилгээ эрхлэгчдийг төрөлжүүлэх дээр анхаарч ажиллаж байна.

Томоохон корпорациуд болон олон үндэстэн дамжсан бизнесүүд нь бизнесийн тасралтгүй байдал, гамшгаас хамгаалах, хямралыг удирдах чиглэлээр төрөл бүрийн эрсдэлийн төлөвлөгөө боловсруулж ирсэн боловч эдгээр нь коронавирус цар тахлаас үүдсэн дэлхийн хямралын үеэр үр дүнд хүрэхгүй байх магадлал өндөр байна. Учир нь энэ цар тахлын хямрал нь бизнес нийлүүлэлт, эрэлт, болон зах зээлийн хослол цочролыг үүсгээд буй.

Эх сурвалж: Google, Apple, Tesla

COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ДЭЛХИЙН ТОМООХОН КОМПАНИУДЫН АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

2020 оны 4-р сарын 20



- Програм хангамж хөгжүүлэгчид вирусийн эсрэг тэмцэх, хүний амь насыг аврахад туслах техник хэрэгслийг боловсруулах, COVID-19 цар тахлын тархалтыг хянах таамаглах үйл ажиллагаанд өөрсдийн хувь нэмрээ оруулж байна. Хамтын ажиллагааны энэ хүрээнд Google ба Apple компаниуд засгийн газрын болон эрүүл мэндийн агентлагуудад вирусийн тархалтыг бууруулахад туслах технологийн хэрэглээг идэвхжүүлэх, хамтарсан хүчин чармайлтыг зарлаж, хэрэглэгчийн нууцлал, аюулгүй байдлыг хангахад анхаарахаар болсон байна.
- GOOGLE ба Apple компаниуд Android болон iOS-н Bluetooth-д суурилан COVID-19 тархалтыг хянах зорилгоор бүтээгдэхүүндээ өөрчлөлт хийж байгаагаа зарласан.
- Түүнчлэн Google компани 5 сарын хугацаанд дэлхийн мэдээллийн байгууллагуудыг холбогдох зар сурталчилгааны менежерийнхээ төлбөрөөс хөнгөлсөн байна. Мөн эдгээр ажлынхаа хүрээнд Google.org нь дэлхийн COVID-19-ийн хариу арга хэмжээнд 50 сая америк долларыг зарцуулахаар төлөвлөсөн байна.

- Amazon компани нь ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах асуудлыг нэн тэргүүнд тавьж, ажилчиддаа хамгаалах маск гэх мэт хувийн хамгаалах хэрэгслийг тарааж, дэлхийн дахин дахь бүх үйл ажиллагааныхаа хүрээнд температурын шалгалтыг хийлээ.
- Түүнчлэн уг компани нь коронавирусын тестийг улам өргөн хүрээнд хямд төсөр болгох төсөл дээр ажиллаж байна.
- Amazon нь 3-р сараас хойш 100,000 шинэ ажлын байрыг шинээр бий болгож, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангах, одоо байгаа ажилчдад зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүний захиалгыг биелүүлэхэд туслах зорилгоор 75,000 ажлын байрыг нэмж оруулав.
- Үүнээс гадна тус компани нь ажилчдын нэг цагийн цалингийн хэмжээг АНУ-д 2 америк доллараар, Канадад 2 канад доллараар, ЕХ-ны олон оронд 2 еврогоор тус тус нэмэгдүүлсэн байна. Илүү цагаар ажилласан ажилчдын цагийн хөлсийг үндсэн цалингийн хэмжээг хоёр дахин нугалсан байдлаар нэмэгдүүлж, COVID-19-р оношлогдсон хүмүүст бүрэн цалинтай чөлөө олгож байна.
- Мөн санхүүгийн бэрхшээлтэй эсвэл хорио цээрийн байдалд байгаа түншүүд хүргэлтийн жолооч нарт болон улирлын холбоотой гэрээт ажилчиддаа зориулж 25 сая америк долларын тусламжийн сан байгуулсан байна.
- Amazon Fresh болон Whole Foods дэлгүүрүүдэд зах зээлээс хүнсний бүтээгдэхүүнийг аль болох хурдан хүргэх хүчин чадлыг нэмэгдүүлж ажиллаж байна.
- Ахуйн хэрэглээний нэн чухал хоол хүнс, эмнэлгийн хэрэгсэл, бусад хэрэгцээтэй бараа бүтээгдэхүүнийг нэн тэргүүнд тавин хурдан шуурхай хүргэхэд анхаарлаа хандуулж байна.
- Amazon болон Alexa төхөөрөмжүүд нь үйлчлүүлэгчдээ байнга COVID-19-тэй холбоотой нөхцөл байдал мэдээллээр хангахад тусалж байна



- Дэлхийн бараг бүх томоохон автомашины үйлдвэрүүд үйлдвэрлэлээ зогсоох төлөвлөгөөтэй байгаагаа зарласан. COVID-19 тархалтыг хязгаарлахын тулд орон нутгийн засаг захиргаа чухал биш үйлдвэрүүдийг зогсоох шийдвэр гарсантай холбоотойгоор Тесла өнгөрсөн сард Сан Францискогийн гадна байрлах АНУ-ын цорын ганц автомашины угсрах үйлдвэрлэлээ зогсоох шаардлагатай болсон.
- Үйл ажиллагааны зардлаа хэмнэх арга хэмжээний хүрээнд Тесла оффис, үйлчилгээний төв, худалдааны цэгийнхээ түрээсийн төлбөрийг "даруй" бүрэн төлж чадахгүй гэдгээ мэдэгдсэн байна. Уг компани нь мөн ажилчдынхаа цалинг бууруулж, гэрээсээ ажиллах боломжгүй ажилчдыгаа цалингүй түр хугацаагаар ажлаа өгөхийг хүсжээ.
- Коронавирусын нөлөөнөөс болж Тесла энэ улирал урьд өмнө таамаглаж байснаас 21 хувиар цөөн (75,000 ширхэг) цахилгаан автомашин зарах төлөвтэй байна.

Эх сурвалж: Google, Apple, Tesla